Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 тоот тушаалын 7 дугаар хавсралт

Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газар

## 2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | Өөрийн үнэлгээ | ХШҮ |
| Гурав, Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ | | | | | | | | | |
| 3.1. | Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогыг тодорхойлох, төлөвлөх, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, төслүүдийг хэрэгжүүлэх хувилбар, хөгжүүлэлтийг хийж, бэлэн | Үйл ажиллагааны зардлаар | - | - | - | | 1. Олон улсын хөрөнгө оруулалтын хэлэлцээрүүд Монгол Улс, БНТУ-ын Засгийн газар хоорондын 1998 оны Хөрөнгө оруулалтыг дэмжих, харилцан хамгаалах хэлэлцээрийг шинэчлэх хэлэлцээ үргэлжилж байна. Туркийн тал 2024 оны шинэ загвар BIT-ээ ирүүлж, хэлэлцээ үргэлжилж буй. Мөн Тайланд, Вьетнам, Энэтхэгтэй ижил төрлийн хэлэлцээг цахимаар хийж байна. 2. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр | 100% | 100 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байдлыг хангуулах; хөрөнгө оруулалт, татах, дэмжих, хамгаалах, ногоон санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх | | | | | (УХОХ) 2026-2030 оны үндсэн хөгжлийн баримт бичгийн хүрээнд УХОХ-ийг боловсруулж байна. Сайдууд болон нийслэлийн удирдлагад чиглэл хүргүүлж, 2025 оны 4 дүгээр сард цахим сургалт зохион байгуулсан. www.invest.gov.mn цахим системээр төслийн санал авч байгаа бөгөөд 200 гаруй санал хүлээн аваад байна. 3. 2025 оны төсвийн хүрээнд хэрэгжих хөрөнгө оруулалтын төслүүд 2025 оны төсвийн тухай хуульд тусгасан хөрөнгө оруулалтын арга хэмжээний хүрээнд: 900 гаруй тэрбум төгрөгийн дүнтэй төслүүдийг нэгтгэсэн. 32 төсөл гэрээ байгуулсан (нийт батлагдсан төслийн 81%). Төсөл сонгон шалгаруулалт нь хөгжлийн бодлого, үр ашиг, санхүүжилтийн боломж, газрын асуудлыг харгалзан хийгдсэн. 4. Стратегийн болон бэлтгэл төслүүд Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсвийн | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүрсэнд дараах чухал төслүүдэд бэлтгэл хангаж байна: Хавдар судлалын үндэсний төв-II КООСЭН хөтөлбөрийг политехник коллежид нэвтрүүлэх Байгалийн түүхийн музей Шүүх шинжилгээний байгууллагын хүчин чадлыг нэмэгдүүлэх Эрдэнэбүрэнгийн УЦС-ын БНХАУ-тай зээлийн хэлэлцээр эцэслэв Гашуунсухайт–Ганцмодын төмөр замын хэлэлцээ урагшилсан "Орано майнинг" ХХК-тай хөрөнгө оруулалтын гэрээний судалгаа хийгдэж байна .5. Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа 2025.03.13-нд "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн форум"-д 200 гаруй оролцогч оролцож, эрх зүйн орчин, бизнесийн соёл, ёс зүйг хэлэлцэв. 2025.05.09-нд "Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн төсөл"-ийн хэлэлцүүлэг болж, 130 орчим төлөөлөгч | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | оролцсон. | | |
| 3.1.1 | "Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах хэлэлцээр"-ийг шинэчлэн болон шинээр байгуулах, сайжруулах санал боловсруулна. | Үйл ажиллагааны зардлаар | Төслийн тоо /Тоо / | Засгийн газрын 2019 оны 93 дугаар тогтоолоор Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн загвар хэлэлцээрийг баталсан. | - | "Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах хэлэлцээр"-ийг шинэчлэн болон шинээр байгуулах саналыг боловсруулсан байна. /3 хэлэлцээрийн төсөл/ | Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2024 оны А/71 дүгээр тушаалаар "Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээр" /BIT/-ийн төслийн асуудлаар хэлэлцээ хийх, эцэслэн тохиролцох үүрэг бүхий Ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан. Монгол Улсын Засгийн газар болон БНТУ-ын Засгийн газар хооронд Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээрийг 1998.03.16-ны өдөр байгуулсан бөгөөд тус хэлэлцээрийг шинэчлэн байгуулах саналыг 2021.11.15 -ны өдөр болсон Монгол, Туркийн ЗГ хоорондын хамтарсан хорооны IX хуралдаанаар шийдвэрлэсэн. Туркийн тал хэлэлцээрийн төслөө 2022 оны 02 дугаар сард ирүүлсэнд Монголын тал хариу хүргүүлж байсан. Туркийн тал Хөрөнгө | 100% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах хэлэлцээрийн загвар /Model BIT/-ыг 2024 оны 08 дугаар шинэчлэн баталсан бөгөөд 12 дугаар сард Монголын талд хүргүүлэн хэлэлцээг үргэлжлүүлэх саналыг тавьсан. Тус асуудлаар ажлын хэсгийн хурлыг 2025.01.28-ны өдөр зохион байгуулж, ажлын хэсгийн гишүүдэд мэдээлэл өгсөн. Хэлэлцээрийн төслийн боломжит хувилбарыг айлын талд хүргүүлэхээр ажиллаж байна. Мөн Тайланд, Вьетнам, Энэтхэг улсуудтай хэлэлцээрийн төслийн талаар цахим уулзалт хийж, хэлэлцээг үргэлжлүүлэхээр ажиллаж байна. | | |
| 3.1.2 | Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төсөл, арга хэмжээний саналыг хүлээн авч, үнэлэх, сонгох, | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц, хувиар | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль батлагдсан. | | "Монгол Улсын 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийг боловсруулж, батлуулсан байна. /100 хувь/ | Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг боловсруулах ажлын хүрээнд "Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийг боловсруулахаар ажиллаж байна. Улсын | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | эрэмбэлэх, хянан баталгаажуулах, бодлогын бичиг баримтыг эцэслэн боловсруулна. | | | | | | хөрөнгө оруулалтын хөтөлбөрт санал авахаар Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны 04 сарын 04-ны өдрийн 01/885 дугаартай албан бичгийг бүх сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нарт хүргүүлсэн. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах ажлын хүрээнд нийт яамд болон Нийслэлийн засаг даргын тамгын газрын хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөр хариуцах албан хаагчдад 2025 оны 04 сарын 11-ны өдөр цахим системийн танилцуулга, ашиглах заавар, чиглэл өгөх сургалтыг зохион байгуулан ажилласан. Улсын хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем /www.invest.gov.mn/-ээр дамжуулан УХОХ-т тусгах саналыг 2025 оны 8 дугаар сар хүртэл хүлээн авахаар төлөвлөсөн. Одоогийн | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байдлаар нийт 200 гаруй төслийн саналыг хүлээн авсан ба ирүүлсэн саналуудын чанар болон иж бүрдлийг шалгах ажил хийгдэж байна. | | |
| 3.1.3 | Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв хийлгэх саналыг хүлээн авч, эрэмбэлэх, тодорхойлох ажлыг зохион байгуулна. | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц, хувиар | Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 2-р хавсралтын IV.1.4:1-д Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын багцад хэрэгжүүлэхээр тусгагдаж батлагдсан. | Төсвийн хөрөнгө оруулалтаар техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв хийлгэх төсөл, арга хэмжээний жагсаалт батлагдсан байна. /100 хувь/ | - | Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр батлагдсан бөгөөд тус хуульд Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайдын багцад "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ, бэлтгэл хангалт /Бүсүүдэд/" төсөл, арга хэмжээ тусгагдсан. Үүний хүрээнд бүх ТЕЗ болон 21 аймгийн ЗД нараас санал авсан бөгөөд 900 гаруй тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий ТЭЗҮ, зураг төсөл хийлгэх төсөл, арга хэмжээний мэдээллийг авч, нэгтгэсэн бөгөөд Төсвийн ерөнхийлөн захирагч нараас ирүүлсэн төслийн | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | саналыг хөгжлийн бодлогын баримт бичигт туссан байдал, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, санхүүжилтийн эх үүсвэрийг хувийн хэвшлээр болон бусад эх үүсвэрээс санхүүжих боломж зэрэг үндсэн шалгуураас гадна бусад төсөвт өртөг, урсгал зардал нэмэгдүүлэх эсэх, газрын асуудлыг харгалзан үнэлж эрэмбэлэн, сонгон шалгаруулалт хийгдэж сонгогдсон төслүүдийн жагсаалтыг Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны А/32, А/44, А/58 дугаар тушаалаар эцэслэн баталж жагсаалтыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт тухай бүр албан бичгээр тус тус хүргүүлсэн. 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар нийт батлагдсан төслийн 81 хувь буюу 32 төслийн гүйцэтгэгч шалгарч гэрээ байгуулсан байна. Үлдсэн төслийн худалдан авах ажиллагаа хэвийн | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үргэлжилж байна. | | |
| 3.1.4 | Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан төслийн хэрэгжүүлэх хувилбар, хөгжүүлэлтийг хийх, бэлэн байдлыг хангахад дэмжлэг үзүүлнэ. | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц, хувиар | - | - | Тухай бүр холбогдох арга хэмжээг авч, зохион байгуулсан байна. /100 хувь/ | Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын багцад туссан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ, бэлтгэл хангалт /Бүсүүдэд/" төсөл, арга хэмжээний багц хөрөнгө оруулалтын зардлаас УХЖТ-ний 2.1.1.4. Хавдар судлалын Үндэсний төв-II байгуулах,1.5.1.2.Бүсчилсэн хөгжлийн зорилт, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан КООСЭН сургалтын хөтөлбөрийг политехник коллежуудэд үе шаттай нэвтрүүлэх, 2.15.1.2.Байгалийн түүхийн шинэ музейн барилга барих, 4.7.4.1.Шүүх шинжилгээний байгууллагын хүчин чадлыг сайжруулах МОН-22 гэх мэт зарим төсөл арга хэмжээний бэлэн байдлыг хангахаар батлагдсан төсөвт өртгийн хүрээнд | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шийдвэрлэсэн. Мөн 2025 онд Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын УЦС-ын төслийн БНХАУ-ын талтай зээлийн хэлэлцээрийг зүцэслэн байгуулсан. Мөн БНХАУ-тай холбогдох хил холболтын төмөр зам болох "Гашуунсухайт-Ганцмод" төслийг эрчимжүүлэх, гэрээ хэлэлцээрийг байгуулах ажлын хэсэгт орж ажилласан ба бусад хөгжлийн томоохон төслүүдийг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллаж байна. Мөн БНФУ-ын "Орано майнинг" ХХК-тай байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээг боловсруулах ажлын хэсэгт гэрээг байгуулахад шаардлагатай судалгаа, мэдээллийг тухай бүр боловсруулан ажилласан. | | |
| 3.1.5 | Дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжихэд олон | Үйл ажиллагааны зардлаар | Мэдээлэл сурталчилгаанд хамрагдах аж ахуйн нэгжийн тооны өсөлт, | - | - | Хувийн хэвшилд нэвтрүүлэх чиглэлээр мэдээлэл сурталчилгааг | 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдөр "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн форум"-ыг зохион байгуулж, дотоодын болон | 100% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | улсын байгууллагаас шаардах Комплаенсын шаардлагыг хангах зорилгоор "Комплаенсын менежментийн тогтолцоо ISO 37301" стандартыг хувийн хэвшилд нэвтрүүлэх чиглэлээр мэдээлэл сурталчилгаар аар хангана. | | хувиар | | | аар хангасан байна. /100 хувь/ | гадаадын хувийн хэвшил; хөрөнгө оруулагчдын 200 гаруй төлөөлөл оролцлоо. Форумын үеэр төр, хувийн хэвшлийн түншлэлийн эрх зүйн орчин, бизнесийн орчны хууль, дүрэм журам, стандарт, гэрээ, хувийн хэвшлийн бодлого, ёс зүйн асуудлыг хэлэлцэв. Мөн 2025 оны 5 дугаар сарын 9-ний өдөр "Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн төсөл"-ийг олон нийт болон оролцогч талуудтай хэлэлцэх зорилгоор ээлжит хэлэлцүүлгийг зохион байгуулж, олон улсын байгууллага, хөгжлийн түнш байгууллага, гадаад улсуудаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамд, мэргэжлийн холбоод, бизнесийн зөвлөл, танхимууд, хөрөнгө оруулагчдын төлөөлөл бүхий 130 гаруй хүн оролцсон. Хэлэлцүүлгийн үеэр Монгол Улс дахь гадаадын хөрөнгө оруулалтын орчин, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хуулийн төслийг нээлттэй хэлэлцэж, бизнесийн орчны хууль, дүрэм журам, стандарт, гэрээ, хувийн хэвшлийн бодлого, ёс зүйн асуудлыг хөндөн ярилцсан. Эдгээр арга хэмжээ нь олон улсын хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх, Монгол Улсад комплаенсын соёлыг төлөвшүүлэх, улмаар ISO 37301 стандартыг хувийн хэвшилд нэвтрүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх юм. | | |
| 3.2. | Хөрөнгө оруулалтын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих, х.о-ын бодлого, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, х.о-ын орчныг сурталчлах, х.о-ыг татах, хөгжлийн төслүүдэд гадаадын шууд хөрөнгө | Үйл ажиллагааны зардлаар | - | - | - | | Шадар сайд Х.Доржхандын 2024.10.25-ны өдрийн 09 тоот тушаалаар холбогдох яам, төрийн болон төрийн бус байгууллага, салбарын мэргэжилтэн, хөндлөнгийн судлаачдын төлөөллүүдийг оролцуулсан Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай | 100% | 100 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | оруулалтыг татах үйл ажиллагаа хэрэгжүүлэх, х.о-ын талаарх эрх зүйн орчин, дотоод зах зээлийн таатай нөхцөлийг хөрөнгө оруулагчид сурталчлах, хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэх хувилбар, хөгжүүлэлтийг хийж, бэлэн байдлыг хангуулах ажлыг уялдуулан зохион байгуулах, х.о-ын бодлоготой уялдуулж төслийн санхүүжилтийн төлөвлөлт, эдийн засаг, санхүүгийн үр ашгийн шинжилгээ хийх, бэлэн байдал хангагдсан төслүүдийн санхүүжилтийн | | | | | хуулийн хуулийн төслийг боловсруулж, ЗГ-ын гишүүдийн саналыг тусгасан бөгөөд үзэл баримтлалыг Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Шадар сайд, Гадаад харилцааны сайд, Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нар хамтран 2024 оны 12 сард баталсан. Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025.04.18-ны өдрийн А/50 болон Монгол Улсын Шадар сайдын 33 дугаар хамтарсан тушаалаар "Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах" чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг шинэчлэн байгуулж, 2025.05.09-ний өдөр олон нийтээр хэлэлцүүлэн, хуулийн төслийг эцэслэн боловсруулсан. Улмаар төслийг 2025.06.04-ний өдрийн ЗГ-ын | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | эх үүсвэрийг тодорхойлох, арга хэмжээг уялдуулан зохион байгуулах | | | | | | хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу бэлтгэл ажлыг хангаж байна. | | |
| 3.2.1 | Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах, тогтворжуулах гэрчилгээ олгох, гадаадын төрийн өмчит хуулийн этгээдэд уул уурхай, эсхүл банк, санхүү, эсхүл хэвлэл мэдээлэл, харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зорилгоор Монгол Улсын хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 33 буюу түүнээс дээш хувийг эзэмших зөвшөөрөл олгох асуудлыг судалж, | Үйл ажиллагааны зардлаар | Хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц, хувиар | - | - | Тухай бүр холбогдох арга хэмжээг авч, зохион байгуулсан байна. /100 хувь/ | Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу БНФУ-ын "Орано майнинг" ХХК-тай байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг судлан хэлэлцэж; эцэслэн Засгийн газрын хуралдаанд танилцуулах үүрэг бүхий Ерөнхий сайдын 2024 оны 27 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2024 оны 140 дугаар тушаалын хавсралтаар байгуулагдсан Эдийн засаг, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан ажлын дэд хэсэгт оролцож, гэрээг байгуулахад шаардлагатай судалгаа, мэдээллийг тухай бүр боловсруулан ажилласан. Тус Монгол Улсын Засгийн газар | 100% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | щийдвэрлэх, үйл ажиллагаанд хяналт тавина. | | | | | | болон Орано Майнинг компани хоорондын Хөрөнгө оруулалтын гэрээг 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр байгуулсан. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-т заасны дагуу тогтворжуулах гэрчилгээ олгуулах хүсэлтэд дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг байнгын болон байнгын бус нийт 17 гишүүнтэй байгуулахаар төлөвлөж байгаа ба зөвлөлийн ажиллах журмын төслийг боловсруулсан. Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах, тогтворжуулах гэрчилгээ олгох, гадаадын төрийн өмчит хуулийн этгээдэд зөвшөөрөл олгох асуудлаар тухай бүр хүсэлт гаргасан байгууллагуудад зөвлөгөө, мэдээлэл өгсөн. | | |
| 3.2.2 | Хөгжлийн бодлогын баримт бичигтэй гадаадын зээл, тусламжийн | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц, хувиар | - | - | Тухай бүр холбогдох арга хэмжээг авч, зохион байгуулсан байна. | Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг 2025 онд багтаан боловсруулахаар | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | санхүүжилтээр шинээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн хүрээнд хийх арга хэмжээг уялдуулах, төслийг хэрэгжүүлэх арга хэмжээг оролцогч талуудын хамт тодорхойлох, холбогдох гэрээ, хэлэлцээрийг эцэслэн тохирч байгуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана. | | | | | /100 хувь/ | ажиллаж байна. Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны А/08 дугаар тушаалаар батлагдсан "Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах аргачлал"-ийн дагуу төсөл, хөтөлбөрийг эрэмбэлэх, үнэлэх, нийгэм, эдийн засгийн нөлөөллийг бодитойгоор тооцоолох сургалтыг зохион байгуулж, тогтмол мэдээ мэдээллээр хангаж ажиллаж байна. Тус ажлын хүрээнд Улсын 2026-2030 оны улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулахдаа салбар яамдаас санал авч ажиллаж байна. Ирүүлсэн саналуудыг үнэлэж, эрэмбэлэн боловсруулахдаа гадаадын зээл, тусламжаар хэрэгжих боломжтой төслүүдийг тодорхойлон салбар яам, сангийн яам болон ОУБайгууллагуудтай хамтран боловсруулахаар | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төлөвлөн ажиллаж байна. "Шинэ сэргэлтийн бодлого, ЗГҮАХ 2024-2028-т туссан төслүүдийн хүрээнд гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг тодорхойлж гаргасан. Тус ажлын хүрээнд салбар яамд болон ОУБайгууллагуудын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулсан. Төслийн санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлох ажлыг тухай бүр зохион байгуулж, санал хүргүүлж ажилласан. Мөн Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголт хөгжлийн банк, Дэлхийн банк болон АНУ, БНСУ, Япон улсын төлөөлөлтэй уулзалтыг зохион байгуулж, цаашдын хамтын ажиллагааны төлөвлөгөөг ярилцан, тохиролцож зээл тусламжийн эх үүсвэрээр одоо хэрэгжүүлж буй болон хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээний талаарх | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | санал солилцсон. | | |
| 3.3. | Ногоон санхүүжилтийн бодлогыг тодорхойлох, холбогдох хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, ногоон санхүүжилт татах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх, ногоон төсөл хөтөлбөрүүдийг бойжуулах, тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавих; | Үйл ажиллагааны зардлаар | - | - | - | | Ногоон санхүүжилтийн бодлогыг тодорхойлох, холбогдох хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд Уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах тухай хуулийн төсөл, хуулийн төсөлд ногоон санхүүжилтийн эрх зүйн орчныг бий болгох суурь зохицуулалт, Үндэсний хэмжээний ногоон санхүүжилтийн стратегийн төсөл, Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Сингапур Улсын Засгийн газар хооронд хэлэлцээрийн төслийг тус тус боловсруулж, өргөн барьж батлуулахад бэлэн болгосон. Ногоон санхүүжилт татах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх, ногоон төсөл хөтөлбөрүүдийг бойжуулах, тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавих хүрээнд Монголын ногоон санхүүгийн корпорацын | 100% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үйл ажиллагааг эхлүүлэхэд шаардлагатай шат дараатай арга хэмжээг хэрэгжүүлж, "Монголын ногоон шилжилтийг эрчимжүүлэх нь" төсөл, Ногоон санхүүжилтийн бодлого, эрх зүйн орчин, байгууллагын чадавх бэхжүүлэх чиглэлээрх "Бэлэн байдлын дэмжлэг (ББД)"-ийн төслийн саналыг тус батлуулж, хэрэгжилтийг эхлүүлсэн. | | |
| 3.3.1 | Үндэсний хэмжээний ногоон санхүүжилтийн стратеги боловсруулж батлуулна. | Үйл ажиллагааны зардлаар | Батлуулах стратегийн баримт бичгийн тоо | Монголын ногоон санхүүжилтийн нөхцөл байдлын судалгаа хийгдсэн. | Ногоон санхүүжилтийн стратегийн төслийг зохих түвшинд хэлэлцүүлж, батлуулсан байна /Батлагдсан стратеги 1/ | - | Эдийн засаг, хөгжлийн сайд, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын хамтарсан 2025 оны А/32/09 дугаар тушаалаар байгуулагдсан Уур амьсгалын өөрчлөлтийг тэсвэрлэх, даван туулах тухай хуулийн төсөл боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсэг 8 бүлэг, 27 зүйл бүхий хуулийн төслийг боловсруулж, 2025 оны 04-р сарын 17-ны өдөр олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хуулийн төсөлд тусгасны дагуу | 100% | 80% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Үндэсний ногоон санхүүжилтийн стратегийн төслийг боловсруулсан. Стратегийн төслийг Тогтвортой хөгжлийн зорилтын санхүүжилтийн таксономиг сайжруулах, албан журмын болгох ажилтай нэгэн зэрэг хэрэгжүүлж байгаа бөгөөд Стратеги, таксономиг хамтад нь 2025 оны III улиралд багтаан ЭЗХ-ийн сайдын тушаалаар батлуулах бэлтгэл ажлыг хангасан. | | |
| 3.3.2 | Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Сингапур Улсын Засгийн газар хооронд хэлэлцээр байгуулах бэлтгэл ажлыг хангаж, хэлэлцээрийн төслийг УИХ-д өргөн барина. | Үйл ажиллагааны зардлаар | Хэлэлцээрийн төслийг УИХ-д өргөн барьсан байх | БНСУ, Япон Улстай хэлэлцээр байгуулсан. | - | Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Сингапур Улс хооронд байгуулах хэлэлцээрийн төслийг УИХ-д өргөн барьсан байна. /Өргөн барьсан хэлэлцээрийн төсөл 1/ | Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Сингапур Улсын Засгийн газар хооронд хэлэлцээр байгуулах бэлтгэл ажлыг бүрэн хангасан. Хэлэлцээрийн төслийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр ГХЯ, СЯ-наас тус тус санал авч нэгтгэсэн. | 100% | 85% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3.3 | Монголын ногоон санхүүгийн корпорацын үйл ажиллагааг эхлүүлэхэд шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | Үйл ажиллагааны зардлаар | Байгуулах гэрээний тоо /тоо/ | Засгийн газрын 2024 оны 172 дугаар тогтоолоор МНСК-ын хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэсэн | - | МНСК-ын хувьцаа захиалгын болон хувьцаа эзэмшлийн гэрээг байгуулж, үйл ажиллагааг нь эхлүүлэх үндсэн нөхцөлийг бүрдүүлсэн байна. /Байгуулсан гэрээ 2/ | Монголын ногоон санхүүгийн корпорацын үйл ажиллагааг эхлүүлэхэд шаардлагатай арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлсэн. 2025 оны I улирлын байдлаар МНСК-ийн гурван хөрөнгө оруулагч болох Монгол Улсын Засгийн газар, түүнийг төлөөлж Хөгжлийн банк 18 сая ам. доллар, хувийн хэвшлийг төлөөлж СиЖиЭф ХХК 5 сая ам. доллар, олон улсын байгууллагыг төлөөлж НҮБ-ын Уур амьсгалын ногоон сан 27 сая ам. долларыг санхүүжилтийн асуудлыг тус тус шийдвэрлэснээр корпорацын үйл ажиллагааг эхлүүлэх үндсэн нөхцөлийг бүрдүүлсэн. Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс Хөрөнгө оруулалтын сан (ХОС)-аар дамжуулан МНСК-д хөрөнгө оруулах шийдвэр, Санхүүгийн зохицуулах хорооны ХОС-д зөвшөөрөл олгох шийдвэрийг гаргуулах, | 100% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | СиЖиЭф ХХК-ийн шинэ хувьцаа эзэмшигчдийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Ингэснээр УАНС болон ХасБанкны хооронд МНСК-д оруулах хөрөнгө шилжүүлэх гэрээ байгуулах нөхцөлийг хангана. | | |
| 3.3. 4 | "Монголын ногоон шилжилтийг эрчимжүүлэх нь" төслийг эцэслэн НҮБ-ын Ногоон эдийн засгийн төлөөх түншлэл (НЭЗТТ)-ээр батлуулж, үйл ажиллагааг нь эхлүүлнэ. | Үйл ажиллагааны зардлаар | НЭЗТТ-д хүргүүлэх төслийн саналын тоо /тоо/ | - | - | Төслийн саналыг НЭЗТТ-д хүргүүлсэн байна. /Төслийн санал 1/ | "Монголын ногоон шилжилтийг эрчимжүүлэх нь" төслийг эцэслэн боловсруулж, НҮБ-ын Ногоон эдийн засгийн төлөөх түншлэл (НЭЗТТ)-д хүргүүлсэн. НЭЗТТ-ийн төрөлжсөн таван байгууллага бүхий Удирдах зөвлөлөөр төслийн саналыг 2025 оны 04-р сард батлуулсан. НЭЗТТ-ийн II үе шат нь урт, дунд хугацааны хөгжлийн бодлогыг уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг зорилт, үйл ажиллагаатай уялдуулах; сайн туршлагыг бүс нутгийн хэмжээнд түгээн дэлгэрүүлэх зорилготой | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бөгөөд үндэсний зохицуулагч сонгон шалгаруулах товыг тогтож, үйл ажиллагааг нь эхлүүлсэн. | | |
| 3.3.5. | Ногоон санхүүжилтийн бодлого, эрх зүйн орчин, байгууллагын чадавх бэхжүүлэх чиглэлээрх "Бэлэн байдлын дэмжлэг (ББД)"-ийн саналыг НҮБ-ын Уур амьсгалын ногоон сан (УАНС)-аар батлуулж, үйл ажиллагааг нь эхлүүлнэ. | Үйл ажиллагааны зардлаар | УАНС-д хүргүүлэх ББД-ийн саналын тоо /тоо/. | - | - | ББД-ийн саналыг УАНС-д эцэслэн хүргүүлсэн байна. /Төслийн санал 1/ | Ногоон санхүүжилтийн бодлого, эрх зүйн орчин, байгууллагын чадавх бэхжүүлэх, нүүрстөрөгчийн зах зээлийн бүртгэл, тооллогын систем хөгжүүлэх чиглэлээрх "Бэлэн байдлын дэмжлэг (ББД)"-ийн төслийн саналыг эцэслэн боловсруулж, НҮБ-ын Уур амьсгалын ногоон сан (УАНС)-д хүргүүлсэн. Төслийн саналыг УАНС-ийн Удирдах зөвлөлөөр 2025 оны 04 дүгээр сард батлуулсан. ББД-ийн санхүүжилт 2025 оны 06-р сарын 05-ны өдөр НҮБХХ-ийн дансанд байршсан бөгөөд төслийн Удирдах хороог байгуулах, эхлэлийн семинар зохион байгуулах товыг тогтож үйл ажиллагааг нь эхлүүлсэн. | 100% | 100 % |
| 3.4. | Төр, хувийн хэвшлийн | Үйл ажиллагаа | - | - | - | | ТХХТТХ-ийн хүрээнд түншлэлээр төсөл | 100% | 100 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | түншлэлээр хэрэгжүүлэх төслийн урьдчилсан үнэлгээг хянан баталгаажуулах, төслийг хөгжлийн бодлогын баримт бичигт тусгах, төслийн бүрэн шинжилгээг хянах, дүгнэх, төслийн сонгон шалгаруулалт болон түншлэлийн гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах, түншлэлийн гэрээний биелэлтэд хяналт тавих, түншлэлээр хэрэгжсэн төслийг төрийн болон орон нутгийн өмчид шилжүүлэх, бүртгэх арга хэмжээг удирдан зохион байгуулах; | ны зардлаар | | | | хэрэгжүүлэхэд салбар яамнаас түншлэлийн төслийн саналыг ирүүлэхдээ ЗГ-ын 2023 оны 404 дүгээр тогтоолоор батлагдсан "Төслийн бүрэн шинжилгээ хийх журам"-ын дагуу төслийн саналаа боловсруулан ирүүлэх ёстой. Үүний хүрээнд түншлэлээр хэрэгжүүлэх төслийн саналыг холбогдох журамд заасан маягт, мэдээллийн дагуу авах, мөн холбогдох байгууллагад заавар зөвлөгөө өгч ажиллаж байна. ЭХЯ-аас 2024 оны а/3937 тоот албан бичгээр "Нэгдсэн сүлжээний горим тохируулах үүрэг бүхий 100 МВт хүртэл хүчин чадал бүхий усан цэнэгт цахилгаан станц төсөл", 2025 оны а/391 дугаар албан бичгээр ирүүлсэн "Байдрагийн усан цахилгаан станц төсөл"-үүдийн санал, холбогдох материал ирүүлснийг судалж урьдчилсан үнэлгээг хийн баталгаажуулан бүрэн шинжилгээ хийх төслийн багийг Төрийн | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нарийн бичгийн даргын 2025 оны А/59 дугаар тушаалаар, 2025 оны А/120 дугаар тушаалаар тус тус байгуулан бүрэн шинжилгээний ажил хийгдэж байна. ЗТЯ-аас “Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр зам төсөл”, "Мөрөн-Улиастай чиглэлийн авто замын төсөл", "Дархан-Алтанбулаг чиглэлийн 113 км авто замыг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчлэх төсөл", “Ховд аймгийн “Ховд”, Хөвсгөл аймгийн “Мөрөн”, Дорнод аймгийн “Чойбалсан” нисэх буудлуудыг 4C ангиллын, Өмнөговь аймгийн “Гурвансайхан” нисэх буудлыг 4D ангиллын болгон ашиглалтыг сайжруулах төсөл”-үүдийг ТХХТ-ээр хэрэгжүүлэх санал ирүүлсэн бөгөөд 1 төслийн бүрэн шинжилгээ хийгдэж дууссанаар 2025 оны 03/706, 01/1533 дугаар албан бичгүүдээр ТХХТ-ийн тухай хуульд заасны дагуу Засгийн газрын хуралдаанаар | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэлэлцүүлэх зөвшөөрөл авхаар Сангийн яаманд хүргүүлсэн. 1 төсөл бүрэн шинжилгээний шатанд, 1 төсөл урьдчилсан үнэлгээ хийгдэж дууссан бөгөөд бүрэн шинжилгээний төслийн баг байгуулахаар холбогдох байгууллагуудаас төслийн багт ажиллах албан хаагчдын мэдээллийг авхаар 2025 оны 03/1417 дугаар албан бичгийг хүргүүлсэн. | | |
| 3.4.1 | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагалдан гарах журам, аргачлалд заасны дагуу хэрэгжилтийг хангаж ажиллана. | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц, хувиар | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль батлагдсан. 2024 оны 01 сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. | - | Холбогдох журам, аргачлалд заасны дагуу хэрэгжилтийг хангаж ажилласан байна. /100 хувь/ | 1.Түншлэлээр хэрэгжүүлэх төслийн саналыг холбогдох журамд заасан маягт, мэдээллийн дагуу авах, мөн холбогдох байгууллагад заавар зөвлөгөөг өгч ажиллаж байна. ЭХЯ-аас ирүүлсэн 2 төслийг судалж урьдчилсан үнэлгээг хийн баталгаажуулан бүрэн шинжилгээ хийх төслийн багийг Терийн нарийн бичгийн даргын 2025 оны А/59 дугаар тушаал, 2025 оны А/120 дугаар тушаалаар тус тус байгуулан бүрэн шинжилгээний ажил | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хийгдэж байна. ЗТЯ-аас ирүүлсэн 1 төслийн бүрэн шинжилгээ хийгдэж дууссанаар 2025 оны 03/706, 01/1533 дугаар албан бичгүүдээр ТХХТ-ийн тухай хуульд заасны дагуу ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл авхаар СЯ-нд хүргүүлсэн. 1 төсөл бүрэн шинжилгээний шатанд, 1 төсөл урьдчилсан үнэлгээ хийгдэж дууссан бөгөөд бүрэн шинжилгээний төслийн баг байгуулахаар холбогдох байгууллагуудаас төслийн багт ажиллах албан хаагчдын мэдээллийг авхаар 2025 оны 03/1417 дугаар албан бичгийг хүргүүлсэн. 1 төслийн урьдчилсан үнэлгээг хийлгэхээр Түншлэлийн төврүү 2025 оны 03/1322 дугаар албан бичгийг хүргүүлсэн. Мөн 2025.01.08-ны өдрийн ЗГ-ын хуралдаанаар Монгол Улсын богино, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан төр, хувийн | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр авах арга хэмжээний талаар Засгийн газрын тэмдэглэлийн төслийг боловсруулан ЗГХЭГ-т албан бичиг хүргүүлж, тус өдрийн ЗГ-ын хуралдааны 2 дугаар тэмдэглэл гарсан. Үүний хүрээнд мөн 2025 оны "Төслийн санал ирүүлэх тухай" 01/271 дугаар албан бичгийг холбогдох сайд нарт хүргүүлсэн болно. 2. УИХ-ын 2024 оны 52 дугаар тогтоолоор Төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, уг хууль болон холбогдох журмыг хэрэгжүүлэх явцад үүсэж буй зарим хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор ЭЗХСайдын 2025 оны А/18 тоот тушаалаар ТХХТТХ-д өөрчлөлт оруулах, санал боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл, үзэл баримтлал, | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дагалдах судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэн холбогдох яамдад хүргүүлж санал аваад байна. | | |
| 3.4.2 | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль болон тус хуулийг дагалдан гарсан журам, аргачлалын хүрээнд сургалтыг зохион байгуулна. | Үйл ажиллагааны зардлаар | Зохион байгуулах сургалтын тоо | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль батлагдсан. 2024 оны 01 сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. | | Холбогдох байгууллагууд ад нийт 3-аас доошгүй удаа сургалт орсон байна. /3 сургалт/ | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн эрх зүйн орчин болон Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан түншлэлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн талаар сурталчлах, танилцуулах, санал солилцож, хэлэлцэх зорилго бүхий "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн форум", 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулсан. Тус форумд гадаадын болон дотоодын хувийн хэвшил, хөрөнгө оруулагчид болон төрийн байгууллагын төлөөллүүдээс бүрдсэн 200 гаруй хүн оролцсон. Тус форумын үеэр ТХХТ-ийн тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу салбар яамд болон хувийн хэвшлээс хэрхэн төр, хувийн хэвшлийн | 100% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | түншлэлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр санаачлан ирүүлэх талаар заавар, чиглэлийг өгч ажилласан. | | |
| 3.4.3 | Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхээр салбар яамдаас ирүүлсэн саналыг ТХХТ-ийн хуульд заасны дагуу судлан, холбогдох арга хэмжээг авч ажиллана. | Үйл ажиллагааны зардлаар. | Хэрэгжилтийн явц, хувиар | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль батлагдсан. 2024 оны 01 сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. | - | Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхээр салбар яамдаас ирүүлсэн саналыг ТХХТ-ийн хуульд заасны дагуу судлан, холбогдох арга хэмжээг авч ажиллана. /100 хувь/ | ЭХЯ-аас 2024 оны а/3937 тоот албан бичгээр "Нэгдсэн сүлжээний горим тохируулах үүрэг бүхий 100 МВт хүртэл хүчин чадал бүхий усан цэнэгт цахилгаан станц төсөл", 2025 оны а/391 дугаар албан бичгээр ирүүлсэн "Байдрагийн усан цахилгаан станц төсөл"-үүдийн санал, холбогдох материал ирүүлснийг судалж урьдчилсан үнэлгээг хийн баталгаажуулан бүрэн шинжилгээ хийх төслийн багийг Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/59 дугаар тушаалаар, 2025 оны А/120 дугаар тушаалаар тус тус байгуулан бүрэн шинжилгээний ажил хийгдэж байна. ЗТЯ-аас "Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр зам төсөл", "Мөрөн-Улиастай чиглэлийн авто замын | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төсөл", "Дархан-Алтанбулаг чиглэлийн 113 км авто замыг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчлэх төсөл", "Ховд аймгийн "Ховд", Хөвсгөл аймгийн "Мөрөн", Дорнод аймгийн "Чойбалсан" нисэх буудлуудыг 4С ангиллын, Өмнөговь аймгийн "Гурвансайхан" нисэх буудлыг 4D ангиллын болгон ашиглалтыг сайжруулах төсөл"-үүдийг ТХХТ-ээр хэрэгжүүлэх санал ирүүлсэн бөгөөд 1 төслийн бүрэн шинжилгээ хийгдэж дууссанаар 2025 оны 03/706, 01/1533 дугаар албан бичгүүдээр ТХХТ-ийн тухай хуульд заасны дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл авхаар Сангийн яаманд хүргүүлсэн. 1 төсөл бүрэн шинжилгээний шатанд, 1 төсөл урьдчилсан үнэлгээ хийгдэж дууссан бөгөөд бүрэн шинжилгээний төслийн баг байгуулахаар холбогдох байгууллагуудаас төслийн багт ажиллах албан хаагчдын | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | мэдээллийг авхаар 2025 оны 03/1417 дугаар албан бичгийг хүргүүлсэн. 1 төслийн урьдчилсан үнэлгээг хийлгэхээр Түншлэлийн төвруу 2025 оны 03/1322 дугаар албан бичгийг хүргүүлсэн. БОУАӨЯ-аас 2025 оны 01/1438 тоот албан бичгээр ирүүлсэн "Улаанбаатар хотод хатуу хог хаягдлаас эрчим хүч үйлдвэрлэх 14МВт-ын суурилагдах хүчин чадалтай цахилгаан станц төсөл", МУ-ын Шадар сайд С.Амарсайханаас 2025 оны ЗГ-2/296 дугаар албан бичгээр ирүүлсэн "Алтанбулаг чөлөөт бүсийн ачаа тээвэр, барилгын материалын логистикийн төсөл"-үүдийг хууль болон журамд заасны дагуу бүрдэл дутуу тул төслийн саналыг буцаасан. | | |
| 3.4.4 | Концессын гэрээний хэрэгжилт, явц, үр дүнд хяналт тавин ажиллаж, холбогдох арга | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц, хувиар | Концессын гэрээний хэрэгжилтийн явцад тухай бүр хяналт тавьсан. | - | Концессын гэрээний хэрэгжилт, явц, үр дүнд хяналт тавин ажиллаж, холбогдох арга | -"Рашаант дахь улсын нөөцийн агуулах төсөл"-ийн концессын гэрээнд салбар яамтай хамтран үнэлгээ хийж ЗГ-т танилцуулахаар бэлтгэл ажлыг хангаж | 100% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэмжээг авч ажиллана. | | | | | хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. /100 хувь/ | байна.-Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км хүнд даацын хатуу хучилттай авто зам төсөл: 2025 оны 03/928 дугаар албан бичгээр "авто зам, замын барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлт"-ийг ЗТЯ-нд хүргүүлсэн. 2025 оны 01/1288 дугаар албан бичгээр "Төслийн ажлыг хэвийн явуулах боломжоор ханган, дэмжлэг үзүүлэн ажиллах" агуулга бүхий хүсэлтийг Өмнөговь аймгийн Засаг даргад хүргүүлсэн.- Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр зам төсөл: Концесс эзэмшигч "Монголиантранс лайн" ХХК-ийн 2025 оны 202 дугаар албан бичгээр "... төмөр замаар хил холбогдох асуудал тодорхойгүй байгаатай холбогдуулан төмөр замын суурь бүтцийг төрийн өмчлөлд авах" агуулга бүхий хүсэлт ирүүлснийг судлан, ЭЗХЯ-ны 2025 оны 01/1557 дугаар албан бичгээр хууль тогтоомж | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | болон концессын гэрээний хүрээнд холбогдох хариуг хүргүүлсэн.-ТНБД-ын 2025 оны А/124 дугаар тушаалын дагуу Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн авто замын төслийг ашиглалтад авах эсэх шийдвэрийг гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд 2025.05.05-09-ний өдрийн хооронд ажилласан. - "Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл"-ийн концессын гэрээнд заасны дагуу Нисэх буудлын зохицуулах хорооны 2025 онд 1 удаагийн хурлыг зохион байгуулсан. Мөн тус төслийн концессын гэрээний дагуу концессын төлбөрийг тооцон, санхүүгийн хэлтэст холбогдох баримт, тооцооллыг гарган хүргүүлж, 2025 онд төлөгдөх 2024 оны сүүлийн хагасын концессын төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлсэн. - "Дархан-Эрдэнэтийн | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | авто замаас Сант сум, Орхон сум чиглэлийн 22.2 км хатуу хучилттай авто зам төсөл"-ийн хувьд Шүүхийн маргаантай холбоотойгоор хуулийн хэлтэст төсөлтэй холбоотой мэдээллийг тухай бүрт гарган өгч ажилласан. Барих-шилжүүлэх 2 төсөл, барих-шилжүүлэхээс бусад 11 төслийн концессын гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, тухай бүр холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. | | |
| 3.4.5 | Монгол Улсын 2025 оны төсөвт батлагдсан концессын барих-шилжүүлэх төрлөөр хэрэгжүүлсэн төслүүдийн санхүүжилтийг хууль, гэрээ, аудитын дүгнэлтэд нийцүүлэн шийдвэрлэнэ. | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц хувиар | Монгол Улсын 2025 оны төсөвт 1 төслийн санхүүжилт батлагдсан. | - | Улсын төсөвт батлагдсан санхүүжилтийг хууль, гэрээ, аудитын дүгнэлтэд нийцүүлэн шийдвэрлэсэн байна. /100 хувь/ | Монгол Улсын Дээд шүүхийн Хяналтын шатны Иргэний хэргийн шүүх хуралдааны 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 001/ХТ2024/00103 дугаар тогтоолоор нэхэмжлэгч "Баянхонгор-Алтай чиглэлийн 126,7 км хатуу хучилттай авто зам төсөл"-ийн концесс эзэмшигч "Макс роуд" ХХК-ийн нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, Засгийн газраас 10,928,624,101 төгрөг, улсын тэмдэгтийн | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хураамжид 54,801,071 төгрөг, нийт 10,983,425,172 төгрөгийг гаруулахаар шийдвэрлэсэн. Үүний дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар хавсралтад тухайн төслийн санхүүжилт 10,983.5 сая төгрөг тусгагдсаныг Эдийн засаг, хөгжлийн яамнаас тухайн төслийн концесс эзэмшигч “Макс рөүд” ХХК-д олгосон 2025 оны Улсын төсөвт санхүүжилт нь тусгагдсан концессын барих-шилжүүлэх төрлийн гэрээгээр хэрэгжиж байгаа 1 төсөл байгаа бөгөөд тус төслийн хүрээнд бий болсон ажлыг 2024 оны 12 дугаар сард 11/06/24 дугаар актаар Улсын комисс үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулахаар шийдвэрлэн, хүлээн авсан. Төслийн гүйцэтгэгч концесс эзэсшигчээс төслийн барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг хяналтын компаниар баталгаажуулан | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ирүүлэх ёстой бөгөөд Үндэсний аудитын газарт аудит хийлгэхээр хүргүүлэх шаардлагатай төслийн баримт материалууд ирээгүй байгаа тул тус төслийн гүйцэтгэлд аудит одоогоор хийгдээгүй байна. Мөн концесс эзэмшигчид төслийн гүйцэтгэл, холбогдох баримт материалыг ирүүлэх тухай 2025 оны 03/824 болон 03/1571 дугаар албан бичгийг тус тус хүргүүлсэн болно. Төслийн гүйцэтгэлд аудит хийлгэж, тус оны санхүүжилтийг олгох арга хэмжээ авч ажиллах тул хугацаа болоогүй. | | |
| 3.4.6 | Монгол Улсын 2026 оны төсөвт концессын гэрээний дагуу олгох хөрөнгө оруулалтын эргэн төлөлт болон улсын төсөвт төвлөрүүлэх концессын төлбөрийн талаарх | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилтийн явц, хувиар | Концессын гэрээний дагуу ажил үргэлжилж буй 2 барих-шилжүүлэх төрлийн төсөл байна. Концессын гэрээнд заасны дагуу Улсын төсөвт төлбөр төвлөрүүлэх | - | Концессын гэрээнд заасны дагуу хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийг 2026 оны улсын төсөвт тусгах санал болон Улсын төсөвт төлбөр төвлөрүүлэх төслийн | 2024 онд хэрэгжилт нь дууссан "Барих-шилжүүлэх" төрлийн "Дархан-Сэлэнгийн авто замаас Шаамар-Зүүнбүрэн-Түшиг Зэлтэрийн боомт хүртэлх хатуу хучилттай авто зам төсөл"-ийн концессын гэрээнд заасны дагуу 2026 онд төлөх хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийг 2026 оны | 100% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | саналыг Сангийн яаманд хүргүүлнэ. /Хөрөнгө оруулалтын эргэн төлөлт болон Концессын төлбөрийн орлого/ | | | нэг төсөл байна. | | орлогын саналыг Сангийн яаманд хүргүүлсэн байна. /100 хувь/ | Улсын төсөвт тусгах саналыг болон Улсын төсөвт төлбөр төвлөрүүлэх "Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл"-ийн концессын гэрээний төлбөрийг гэрээнд заасны дагуу тооцоолон саналыг 2026 оны Улсын төсвийн төсөлд тусгуулахаар 2026 оны 6 дугаар сард Санхүүгийн хэлтэст тус тус хүргүүлээд байна. | | |
| 3.5. | Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах, тэргүүлэх ач холбогдол бүхий хөгжлийн төсөл, хөтөлбөрийг эрэмбэлэх, хянан баталгаажуулах, нийгэм, эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн нэгдсэн бодлого, арга | Үйл ажиллагааны зардлаар | - | | | | Тэргүүлэх ач холбогдол бүхий "Шинэ сэргэлтийн бодлого, ЗГҮАХ 2024-2028-т туссан бэлэн байдал хангагдсан хөгжлийн төслүүдийн эх үүсвэрт шийдвэрлэх ажлын тухай бүр салбар яамд болон ОУБайгууллагуудтай хамтран ажилласан. 2025 онд Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын УЦС-ын төслийн БНХАУ-ын талтай зээлийн хэлэлцээрийг эцэслэн байгуулсан. Говийн бүсийн ус хангамжийг сайжруулах "Орхон- | 100% | 100 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэмжээг тодорхойлох, төслүүдийг нэгдсэн удирдлагаар хангах, төслийн оролцогч талуудтай хамтран ажиллаж зохион байгуулах, хөгжлийн төслүүдийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх, төслийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах болон эрсдэлийн удирдлага, зохицуулалтаар хангах, эдийн засгийн коридорын төсөл хөтөлбөрүүдийг тохиролцох, хэрэгжилтэд хяналт тавих; | | | | | Онги" төслийн бэлэн байдлыг хангуулж БОУАӨЯамтай хамтарсан ажлын хэсэг байгуулагдан төслийг ойрын хугацаанд эхлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх ажилд оролцон ажилласан. Мөн БНХАУ-тай холбогдох хил холболтын төмөр зам болох "Гашуунсухайт-Ганцмод", "Ханги-Мандал", "Шивээхүрэн-Сэхээ" зэрэг төслүүдийг эрчимжүүлэх, гэрээ хэлэлцээрийг байгуулах ажлын хэсэгт орж ажилласан ба бусад хөгжлийн томоохон төслүүдийг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажилласан. Мөн сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд АХБ-тай хамтран ажиллаж байна. Мөн Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголт хөгжлийн банк, Дэлхийн банк болон АНУ, БНСУ, Япон улсын төлөөлөлтэй уулзалтыг зохион байгуулж, цаашдын хамтын ажиллагааны төлөвлөгөөг ярилцан, | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тохиролцож зээл тусламжийн эх үүсвэрээр одоо хэрэгжүүлж буй болон хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээний талаарх санал солилцсон. Мөн Дорноговь аймагт Газрын тос боловсруулах цогцолборын нэмэлт зээлийн хэлэлцээрийг байгуулах ажилд оролцон ажилласан. Монгол Францын хамтарсан ураны төслийн ажлыг хэсэгт орж ажилласан. Зүрх судасны үндэсний төвийн санхүүжилтийг шийдвэрлэхээр ЕСБХБ-д хүсэлт хүргүүлсэн. Мөн зарим тоног төхөөрөмжийг Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Чойр-Сайншанд чиглэлийн 220 кВ ЦДАШ-ын санхүүжилтийншийдвэрлэх ажлын хүрээнд ЕСБХБ-тай зээлийн хэлэлцээрийг байгуулсан. | | |
| 3.5.1 | Бэлэн байдал хангагдсан | Үйл ажиллагаа | Хэрэгжилтийн явц, хувиар | Мега төслүүдийг | - | Хөгжлийн төслүүдийн | Тэргүүлэх ач холбогдол бүхий "Шинэ | 100% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, үйлдвэржилт, дэд бүтэц, хөгжлийн төслүүдийн санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлох, нийгэм, эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн нэгдсэн бодлого тодорхойлно. | ны зардлаар | | хариуцсан салбар яамд болон холбогдох байгууллагууд тай уулзалтыг зохион байгуулж төслүүдийн төлөвлөлт, мониторинг, үнэлгээ болон төслүүдийг хэрэгжүүлэхэд учирч буй саад бэрхшээлүүди йн талаар мэдээлэл солилцож арга зүйн дэмжлэг үзүүлсэн. | | санхүүжилтийн эх үүсвэр, нэгдсэн төлөвлөгөө боловсруулж, гэрээ хэлэлцээр байгуулах бэлтгэл ажил хангагдсан байна. /100 хувь/ | сэргэлтийн бодлого, ЗГҮАХ 2024-2028-т туссан бэлэн байдал хангагдсан хөгжлийн төслүүдийн эх үүсвэрт шийдвэрлэх ажлыг тухай бүр салбар яамд болон ОУБайгуулаагуудтай хамтран ажилласан. 2025 онд Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын УЦС-ын төслийн БНХАУ-ын талтай зээлийн хэлэлцээрийг эцэслэн байгуулсан. Говийн бүсийн ус хангамжийг сайжруулах "Орхон-Онги" төслийн бэлэн байдлыг хангуулж БОУАӨЯамтай хамтарсан ажлын хэсэг байгуулагдан төслийг ойрын хугацаанд эхлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх ажилд оролцон ажилласан. Мөн БНХАУ-тай холбогдох хил холболтын төмөр зам болох "Гашуунсухайт-Ганцмод", "Ханги-Мандал", "Шивээхүрэн-Сэхээ" зэрэг төслүүдийг эрчимжүүлэх, гэрээ хэлэлцээрийг байгуулах ажлын хэсэгт орж ажилласан ба бусад | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хөгжлийн томоохон төслүүдийг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажилласан. Мөн сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд АХБ-тай хамтран ажиллаж байна. Мөн Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголт хөгжлийн банк, Дэлхийн банк болон АНУ, БНСУ, Япон улсын төлөөлөлтэй уулзалтыг зохион байгуулж, цаашдын хамтын ажиллагааны төлөвлөгөөг ярилцан, тохиролцож зээл тусламжийн эх үүсвэрээр одоо хэрэгжүүлж буй болон хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээний талаарх санал солилцсон. Мөн Дорноговь аймагт Газрын тос боловсруулах цогцолборын нэмэлт зээлийн хэлэлцээрийг байгуулах ажилд оролцон ажилласан. Монгол Францын хамтарсан ураны төслийн ажлыг хэсэгт орж ажилласан. Зүрх судасны үндэсний | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төвийн санхүүжилтийг шийдвэрлэхээр ЕСБХБ-д хүсэлт хүргүүлсэн. Мөн зарим тоног төхөөрөмжийг Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Чойр-Сайншанд чиглэлийн 220 кВ ЦДАШ-ын санхүүжилтийншийдвэр лэх ажлын хүрээнл ЕСБХБ-тай зээлийн хэлэлцээрийг байгуулсан. | | |

*Үнэлсэн:* *И.Батхүү*

*Төрийн нарийн бичгийн дарга* ........................ /................................/

*(албан тушаал )* *(гарын үсэг)*

*2025.06.25*
*(огноо)*

*Тайлагнасан:* *Б.Анар*

*Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга* ........................ /................................/

*(албан тушаал )* *(гарын үсэг)*

*2025.06.25*
*(огноо)*